



БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Оюуны өмчийн эрх зүйн маргаан¹)

LOUIS VUITTON ЗЭРЭГ ДЭЭД ЗЭРЭГЛЭЛИЙН БРЭНДИЙН ЦҮНХИЙГ ХУВИЙН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН ӨӨРЧЛӨН ЗАСВАРЛАХ НЬ БАРААНЫ ТЭМДГИЙН ЗӨРЧИЛ БИШ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: Decision of Supreme court 2024Da311181.

Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 02 сарын 26-ны өдөр.

Шийдвэрийн төлөв: Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг доод шатны шүүхэд буцаасан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Хувцас, эд хэрэглэл өөрчлөн засварладаг жижиг дунд үйлдвэрлэлийн А компани нь өөрийн үйлчлүүлэгчээс түүний өмчлөлийн тансаг зэрэглэлийн “Louis Vuitton” брэндийн цүнхийг өөрчлөн засварлах захиалга авч цүнхийг захиалгын дагуу зохих ёсоор өөрчлөн засварлан үйлчлүүлэгчид буцаан өгсөн байна. Үүний улмаас “Louis Vuitton” компани нь хувцас, эд зүйлсийг өөрчлөн засварладаг жижиг дунд үйлдвэрлэлийн А компанийн эсрэг **барааны тэмдэгтийн зөрчил гаргасан хэмээн хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргажээ.**

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР:

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр: Анхан шатны шүүхээс жижиг, дунд үйлдвэрлэлийн А компанийг БНСУ-н Барааны тэмдэгтийн тухай хуулийн 108-р зүйлд² заасан барааны тэмдгийн зөрчил гаргасан гэж үзэж 15 сая воны торгууль ногдуулсан бөгөөд Патентын хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээн шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүхийн шийдвэр:

БНСУ-н Дээд шүүхээс тансаг зэрэглэлийн “Louis Vuitton” компанийн нэр дээр барааны тэмдгийн бүртгэл бүхий цүнхийг хувийн хэрэгцээнд зориулан өөрчлөн

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://www.scourt.go.kr/portal/news/NewsViewAction.work;jsessionid=Xueibs824O46OI3ahiTyi02AzoWhlFxVbbjZSE9O7h0clzCxttBCINJUvbxvlI2a.BJEUWS04_servlet_SCWWW?pageIndex=1&searchWord=&searchOption=&qubun=6&seqnum=2941 Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

²Trademark Act of Republic of Korea.

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=60480&lang=ENG (Last visit:2026.04.06)



засварласан нь барааны тэмдгийн зөрчил болохгүй гээд дараах дүгнэлт, тайлбарыг гаргажээ.

Хариуцагч нь барааны тэмдгийн бүртгэлтэй тансаг зэрэглэлийн цүнхийг өөрчлөн өөр загвар, хийц бүхий цүнх, хэтэвч үйлдвэрлэх явцад тус бараан дээрх өвөрмөц хээ, дүрс бүхий бүртгэлтэй барааны тэмдэг нь хэвээр байсан нь барааны тэмдгийг хууль бусаар хуулбарлан ашигласан гэж үзэх үндэслэлтэй хэдий ч энэ нь тухайн бүтээгдэхүүнийг олон тоогоор үйлдвэрлэн худалдан борлуулж ашиг олох зорилгогүй байсан, зөвхөн өөрийн үйлчлүүлэгчийн өмчлөлд байх тансаг зэрэглэлийн цүнхийг түүний захиалгын дагуу өөрчлөн засвар хийж өөрийнх нь өмчлөлд буцаан шилжүүлснийг барааны тэмдгийн зөрчил гэж үзэхгүй. Учир нь Барааны тэмдэгтийн тухай хуулийн 108-р зүйлд заасан барааны тэмдгийн зөрчил нь бизнес эрхлэгч уг барааны тэмдгийг олноор нь нааж олшруулан зах зээлд ашиг олох зорилгоор худалдан борлуулсан онцгой нөхцөл байдлыг хэлэх бөгөөд онцгой нөхцөл байдал бий болсон эсэхийг тодорхойлохдоо уг бүтээгдэхүүн хэний өмчлөл болох, өмчлөгчийн хүсэл зориг, уг бүтээгдэхүүнийг засварлаж буй шалтгаан сэдэл, тоо хэмжээ, засвар үйлчилгээ хийлгүүлсэн төлбөрийн нөхцөл зэргийг цогцоор нь авч үзэх ёстой. Бүтээгдэхүүнийг засварлан өөрчилсөн этгээдийг барааны тэмдгийн зөрчил гаргасан эсэх онцгой нөхцөл байдлыг нотлох үүрэг нь барааны тэмдгийн эзэмшигчид ноогдоно. Мөн тухайн цүнхний өмчлөгч өөрийн эд хөрөнгөө өөрчлөх, засах, сэлбэх нь өмчлөгчийн жам ёсны эрхэд хамаарна гэж дүгнэжээ.

БНСУ-н дээд шүүхээс дээрх шийдвэрийг тайлбарлахдаа энэхүү маргаан нь хууль зүйн ач холбогдлоос гадна олон улсын анхаарлыг татсан маргаан бөгөөд нийгэм, зах зээлд үзүүлэх үр дагавар нь ихээхэн өндөр маргаан юм гэж тайлбарлажээ. Түүнчлэн энэхүү шийдвэр нь эрх зүйн зарчмыг тунхаглаж, барааны тэмдгийн зөрчлийн онцгой нөхцөл байдлын шалгуурыг шүүх тогтоосон нь чухал ач холбогдолтой хэмээн тайлбарласан байна.

Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож Патентийн хэргийн давж заалдах шатны шүүхэд хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаажээ. Патентийн хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг дахин шийдвэрлэхдээ тус улсын ИХШХШтХ-н 436 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу дээд шүүхийн тогтоосон хэргийн үйл баримт, хууль зүйн дүгнэлтийг өөрчлөхгүйгээр зөвхөн буцаасан асуудлын хүрээнд шийдвэрлэнэ.